

Малын эрүүл мэндийн өнөөгийн байдал,
цаашид авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүд “Малын эрүүл мэндийн өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний тухай” Засгийн газрын гишүүн, Хүнс хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунайн мэдээлэл, холбогдох баримт материалтай ажлын журмаар танилцаад ЗӨВЛӨМЖ болгох нь:

Нэг. Монгол Улсын Их Хуралд:

Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулиудыг шинэчлэн найруулах замаар малын эрүүл мэндийг сайжруулах эрх зүйн орчинг боловсронгуй болгох.

Хоёр. Монгол Улсын Засгийн газарт:

1. Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын зөвлөмж, шинжээчдийн дүгнэлтийг харгалзан Мал, эмнэлгийн албаны үндэсний тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн өөрчлөх, бодлого, хяналт, үйлчилгээг мэргэжлийн удирдлага, мэдээллийн нэгдсэн тогтолцоо, удирдлагатай байхаар зохион байгуулах,

2. Монгол Улсын баруун бүс нутгийг шүлхий өвчнөөр тайван, вакцин хэрэглэдэггүй бүс болгон зохион байгуулахад шаардагдах хөрөнгө, санхүүжилтийг шийдвэрлэх,

3. Малын гоц халдварт өвчинтэй тэмцэх, эрт сэрэмжлүүлэх, хариу авах арга хэмжээний бэлэн байдлын чадавхийг бэхжүүлэх зорилгоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Мал эмнэлэг, үржлийн газрын дэргэд шүлхийн вакцин, оношлуур, ариутгал халдваргүйтлийн бэлдмэл, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, дуудлагын машин бүхий шуурхай ажлын нэгж байгуулах,

4. Сум, багийн мал эмнэлгийн үйлчилгээний анхан шатны хувийн нэгжүүдийн материаллаг баазыг бэхжүүлэх, малын үзлэг, шинжилгээний хашаа, угаалгын тоног төхөөрөмж, оношлогоо, шинжилгээний лаборатори, эм, биобэлдмэл, вакцин хадгалах зориулалтын агуулахаар хангах,

5. Малын эмч, мал зүйч, зоотехникч нарыг хөдөлмөрийн хүнд, хортой, халдвартай нөхцөлд хамруулах асуудлыг судлан шийдвэрлэх,

6. Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лабораторийн техник, технологийг шинэчлэх, шинжилгээний болон халдвар хамгаалал, биоаюулгүй байдлын чадавхийг сайжруулах,

7. Мал эмнэлгийн тархвар судлал, мал эмнэлгийн статистик болон загварчлал, малын гоц халдварт болон зооноз өвчний оношлогоо, эм зүй, байгаль цаг уурын өөрчлөлттэй холбоотой үүсэх малын эмгэгийг судлаач зэрэг нарийн мэргэжлээр жил бүр таваас доошгүй бакалавр, магистр, хоёроос доошгүй докторыг Засгийн газрын тэтгэлгээр өндөр хөгжилтэй оронд бэлтгэх.